



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 19


Бөхт

ГБaгийн Иргэдийн Нийтийн Хурлын даргын ажлыг  
үнэлж, дүгнэх, урамшуулал олгох журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн сумын ИргэдийнТөлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Багийн ИНХ-ын даргын ажлыг үнэлж дүгнэх, урамшуулал олгох журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг БИНХ-ын дарга, Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчид болон нарийн бичгийн дарга Д.Уранбилэг нарт даалгасугай.

ДАРГА



У.АЛТАНХҮҮ

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 -р сарын 12-ны өдрийн 19 -р тогтоолын хавсралт

ӨНДӨРШИЛ СУМЫН БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН  
ДАРГЫН АЖЛЫГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ ЖУРАМ

**Зорилго:** Багийн ИНХурал, түүний Тэргүүлэгчдээс нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж буй ажлыг эрчимжүүлэх, Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс Багийн ИНХ-ын ажлыг удирдан чиглүүлж, хяналт тавих, ажлыг нь үнэлж дүгнэх, урамшуулал олгоход оршино.

**Нэг. Шалгуур үзүүлэлт:**

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл	Тоон шалгуур	Оноо
1	БИНХ болон Тэргүүлэгчдийн хуралдааныг тогтмолжуулах	Хурлаар хэлэлцэх асуудал, дараалал, дотоод журам, хуралдааны бэлтгэл хангах төлөвлөгөө, гарах шийдвэрийн төслийг урьдчилан бэлтгэсэн байх Хуралдааны материалыг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу үйлдэж, архивлаж хүлээлгэн өгсөн байх	БИНХ 2 удаа, Тэргүүлэгчдийн хурал 4 удаа	5 оноо
2	БИНХ-ын Тэргүүлэгчдийн жилийн ажлын төлөвлөгөөтэй ажиллах	Төлөвлөгөөг Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн баталсан байх Төлөвлөгөөний хэрэгжилтийг БИНХ-ын хуралдаанд тайлагнасан байх Ажлын тайланг улирал бүр ИТХ-ын ажлын албанд ирүүлсэн байх	2 удаа /хагас, бүтэн жилээр/	5 оноо
3	Багийн Засаг даргын ҮАХ-ийг батлах, тайланг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгөх	ҮАХ-ийг хурлаараа хэлэлцсэн байх Хэрэгжилтийг хурлаараа хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгсөн байх	2 удаа /хагас, бүтэн жилээр/	5 оноо
4	Хууль, тогтоомж, дээд шатны болон сум, багийн хурал, Тэргүүлэгчдийн хурлаас гарсан шийдвэрийг сурталчилах	Хууль, тогтоомжоор багийн иргэддээ сургалт зохион байгуулах Гарсан шийдвэрийг сурталчилах, Шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах	Сургалт 2 удаа Шийдвэр сурталчилах 2 удаа Тайлагналт жилийн эцэст 1 удаа	5 оноо
	Багийн иргэдийнхээ үндсэн ба журам үүргийн биелэлтийг	ГХУС, сахилга дэг журмыг бэхжүүлэх талаар зохиосон ажил	2 үр дүнтэй ажил зохиосон байх	5 оноо



**ДУНГОВЬ АЙМГИЙН  
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 20


Бөхт

Сумын төсөв, санхүү, ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалтанд хяналт шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн сумын ИргэдийнТөлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын төсөв, санхүү, ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалтанд хяналт шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх журам хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг ИТХ-ын Хороодод үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчид болон нарийн бичгийн дарга Д.Уранбилэг нарт даалгасугай.

ДАРГА



У.АЛТАНХҮҮ

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 04-р сарын  
12-ны өдрийн 20-р тогтоолын хавсралт

ӨНДӨРШИЛ СУМЫН ТӨСӨВ САНХҮҮ, ОНХС-ИЙН ТӨЛӨВЛӨЛТ  
ГҮЙЦЭТГЭЛ, ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ,  
ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ӨГӨХ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Нийтийн сонсголын тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоол журам, Засгийн газар, холбогдох яамнаас гаргасан журам, ИТХ-ын Тэргүүлэгчдээс баталсан энэхүү журам нь уг ажлыг зохион байгуулах үндэслэл болно.

**Хоёр. Журмын зорилго**

2.1. Холбогдох хуулийн хэрэгжилтийг ханган төсвийн хөрөнгийн ил тод байдлыг сайжруулах, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэхэд Төлөөлөгч, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх,

2.2. Төсвийн орлогын бүрдүүлэлт, зардал ил тод байж иргэн хүнд хүрэх ажил үйлчилгээний үр өгөөжийг сайжруулах,

2.3. Төсвийн болон хандив, тусламж, сангийн зарцуулалтыг үр ашиг, орон нутагт үзүүлэх өгөөж, иргэдэд хүргэх ач холбогдлыг нэмэгдүүлэх.

**Гурав. Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд оролцогч талууд**

3.1. ИТХ-ын Тэргүүлэгч, Хурлын хороо

3.2. Засаг дарга, Засаг даргын Тамгын газар

3.3. Төсөвт байгууллагууд

**Дөрөв. Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх хэлбэр**

4.1. Төсөв, орон нутгийн хөгжлийн сан, холбогдох хөрөнгийн зарцуулалтын тайлан авах, мэдээ судалгаа гаргуулах,

4.2. Үйл ажиллагааны тайлан, шилэн дансны мэдээлэлтэй танилцах, хэлэлцэх

4.3. Үйл ажиллагааны явц, хэрэгжилттэй танилцах,

4.4. Төлөвлөгөө, удирдамжийн дагуу хэсэгчилсэн, сэдэвчилсэн хяналт хийх,

4.5. Төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн асуудлаар олон нийтээс судалгаа авах,

4.6. Тодорхой асуудлаар "Нийтийн сонсгол", "Нээлттэй хэлэлцүүлэг" хийх,

4.7. Гарсан зөрчил дутагдал, хэрэгжээгүй шийдвэр, тулгамдсан асуудлаар Төлөөлөгч, Хурлын хорооноос холбогдох албан тушаалтанд асуулга тавьж хариу мэдээллийг авч хэлэлцэх,

4.8. Төсвийн хөрөнгийн үр ашиг, ажил үйлчилгээнд гаргасан ахиц өөрчлөлт, иргэд, хамт олны сэтгэл хангамжийн байдлыг судалж дүгнэлт гаргах,

4.9. Баталсан төсвийн зарцуулалт, үр дүнг улирал бүрээр дүгнэх,

4.10. Дотоод аудитын баг, иргэний хяналтын бүлэг байгуулж ажиллуулах, санал дүгнэлттэй нь танилцах.

**Тав. Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний байгууллагуудаас хийх хяналт, шинжилгээ, үнэлгээ**

5.1. Төсөв, санхүү, өмчтэй холбоотой хууль тогтоомжийг сурталчилах, үйл ажиллагаатай холбон таниулах, хийсэн ажилд нь хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх,

5.2. Төсөвт байгууллагуудын чиг үүргийн дагуу хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний биелэлтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх,

5.3. Төсвийн орлогын бүрдүүлэлт, төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавих,

5.4. Шилэн дансны мэдээллийн ил тод байдал, иргэдэд хүрч буй хүртээмжийн байдлыг хянах,

5.5. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, төсвийн гүйцэлтгэл, хөрөнгийн зарцуулалтын үр дүнг ажил үйлчилгээний чанар, үр өгөөжтэй уялдуулан тооцож, үнэлэлт дүгнэлт өгөх,

5.6. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын биелэлтэнд улирал тутам хяналт шинжилгээ хийж, үнэлж дүгнэх

5.7. Батлагдсан төсөв, хөрөнгө оруулалтын хүрээнд дэд бүтцийг хөгжүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээг өргөтгөх талаар гаргасан шийдвэр, санаачлага, түүний үр дүнг хянах, үнэлэх,

5.8. Хурлаас баталсан төсөл, хөтөлбөр, тогтоол шийдвэрийн биелэлтийг зарцуулсан төсвийн хөрөнгөтэй нь харьцуулан хяналт, шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх,

5.9. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын үр дүн, өгөөжийн байдалд хяналт шинжилгээ хийх,

5.10. Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн дотоод аудитын ажилд хяналт тавих,

5.11. Төсвийн болон ОНХС холбогдох бусад сангуудын төлөвлөлт, зарцуулалт, үрд үнд хяналт шинжилгээ хийж явц үр дүнг хэлэлцэж, нийтэд мэдээлэх,

5.12. Бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа, явц, үр өгөөжийг иргэдэд мэдээлэх,

5.13. Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих.

**Зургаа. Хяналт шинжилгээ үнэлгээний оролцоо**

6.1. ИТХ-ын Тэргүүлэгчдийн оролцоо:

- Хяналт шинжилгээ хийх удирдамжийг боловсруулан хэлэлцэж, батлах,
- Хяналтын ажлыг арга зүйгээр удирдан чиглүүлэх
- Хяналтын явцыг удирдан зохион байгуулах,
- Хяналт шинжилгээний тайлан дүн мэдээ, цаашид хэрэгжүүлэх зөвлөсж чиглэлийг хэлэлцэх.

6.2. Хурлын хороодын оролцоо:

- Өөр өөрсдийн чиглэлийн дагуу санал, дүгнэлт боловсруулах,
- Хяналт шинжилгээ хийх арга зүйн мэдээлэл, ном, гарын авлагыг цуглуулж судлуулах,
- Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг Хорооны хурлаар хэлэлцэх,
- Зөвлөмж, чиглэл гаргах,
- Хурлын Тэргүүлэгчдийг үнэн зөв бодитой мэдээллээр хангах.

6.3. Төлөөлөгч, иргэд, олон нийтийн оролцоо:

- ✓ Хурлын байгууллагаас гаргасан шийдвэртэй танилцах,
- ✓ Өөрийн хүсэлтээр болон эрх бүхий албан тушаалтны чиглэл зөвлөмжөөр хяналт шинжилгээ үнэлгээний ажилд оролцох,
- ✓ Төсөв болон ОНХС-ийн зарцуулалтад хяналт шинжилгээ хийх олон нийтийн хяналтын бүлэг, зөвлөл байгуулан ажиллуулж дүнг танилцах шаардлагатай бол холбогдох шатны хуралд хэлэлцүүлэх,
- ✓ Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн тухай мэдээлэл авах,
- ✓ ОНХС-гийн зарцуулалтад хяналт тавих олон нийтийн хяналтын бүлгийн ажилд оролцох,
- ✓ Төсөв, түүний зарцуулалт, үр өгөөжийн талаар мэдээллийн ил тод байдлыг хангуулах,
- ✓ Төсвийн зарцуулалт, үр өгөөжөөр иргэдээс судалгаа авч дүгнэлт хийх.

6.4. ЗДТГ, мэргэжлийн хүмүүсийн оролцоо:

- Хурлаас хяналт, шинжилгээ эхийх ажлын хэсэгт ЗДТГ болон мэргэжлийн байгууллагын оролцоог хангах,
- ИТХ, Тэргүүлэгчид, Хороо, Төлөөлөгчөөс өгсөн шийдвэр, зөвлөмж, албан бичиг бүрийг бүртгэл хяналтанд авч хариуг мэдээллэх,
- Шаардагдах мэдээлэл, тайлан, судалгааг гаргаж өгөх,
- ХШҮ-ний дараа өгсөн зөвлөмж, шийдвэрийн мөрөөр ажил зохиож дүнг мэдээлж байх.

Долоо. Төсвийн тухай хуулийн 8, 14, 16, 23.2, 56-60, 63-69-р зүйлүүдийн хэрэгжилтийг зөв зохион байгуулах, ХШҮ хийж үнэлэлт дүгнэлт гаргах

7.1. Төсвийн тухай хуулийн зүйл заалт бүрийг сайн таниулж, биелэлтийг хяналтанд авах,

7.2. Орон нутгийн төсвийн үе шат бүрээр хяналт хийх,

7.3. Засаг дарга, Санхүүгийн албанаас төсөв боловсруулалт, хэрэгжилтийг явцыг Хурлын хороо, Тэргүүлэгчдийн хурлаар танилцах, саналаа өгөх,

7.4. ОНХС-гийн санал авалт, түүний үр дүн, хэрэгжилтэнд хяналт тавих,

7.5. Төсөв, ОНХС-гийн төлөвлөлт, зарцуулалтад Төлөөлөгч, иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог өргөтгөх,

7.6. Төсвийн байгууллага бүр дотоод хяналтын баг, ОНХС-ийн зарцуулалтад олон нийтийн хяналтын бүлэг байгуулж ажиллуулах, дүнг сонсох,

7.7. ОНХС-ийн хөрөнгөөр барьж байгуулсан бүтээн байгуулалтын ажлын үр дүнгээр иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэлт гаргах,

**Найм. Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих.**

8.1. Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиуд Засгийн газрын 2014 оны 384-р тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахи хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай" журмыг байнга сурталчилж, хэрэгжилтэнд нь хяналт шинжилгээ хийх,

8.2. Шилэн дансны тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.1 дэх хэсгийг дагуу төсвийн мэдээллээ ил тод болгох, төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагын жагсаалтыг жилийн төсөвтэй нь хамт баталж хяналт тавих,

8.3. Шилэн дансны тухай хуулийн 3-9-р зүйлийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх төсөв, төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын тайлан мэдээ, хөрөнгийн зарцуулалт, үр дүнг нийтэд ил тод цахим сайт, самбар, булангаар мэдээлэх, Хурлаас явц байдлыг хянаж эрчимжүүлэх,

8.4. Шилэн дансны тухай хуулийн 7-р зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу шилэн дансны мэдээллийг хариуцсан ажилнуудыг томилуулан мэдээллийн явцыг тэднээс асууж хянах,

8.5. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6-р зүйлийг үндэслэн Үйл ажиллагааны ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал, Төсөв санхүүгийн ил тод байдлыг нээлттэй болгож иргэдэд мэдээллэж байгаа ажлын үр өгөөж,

8.6. Хурлын төлөөлөгч, иргэд нутаг дэвсгэрийн аль ч байгууллагаас нууцад хамаарахаас бусад мэдээлэл авах, танилцах,

8.7. Гаргасан шийдвэр бүрээ ил тод мэдээлэх, сурталчилж таниулах,

8.8. Төсвийн хөрөнгө, ОНХС, СХС, Хөдөлмөр эрхлэлт амьжиргааг дэмжих, бусад сонгуулийн хөрөнгийн орлого, зарлагыг ил тод мэдээллэх, хяналт тавих.

**Ес. Хяналт шинжилгээ, үнэлэлт дүгнэлтийн мөрөөр авах арга хэмжээ, удирдлага зохион байгуулалт**

9.1. ХШҮ-ний дүн, түүний мөрөөр зохиох ажлын төлөвлөгөө гаргаж холбогдох хурлөөр хэлэлцэж батлах,

9.2. ХШҮ-ний мөрөөр хийж, хэрэгжүүлэх ажлын талаар зөвлөмж, албан даалгавар, тэмдэглэл гарган холбогдох албан тушаалтанд өгөх,

9.3. ХШҮ-ний мөрөөр хийсэн ажил, гарсан үр дүнг тодорхой хугацаанд хянаж хэлэлцэж байх,

9.4. Тодорхой албан тушаалтны илтгэл, мэдээллийг сонсох,

9.5. "Нээлттэй хэлэлцүүлэг" хийх, иргэдэд тайланг тавиулах зэргээр хяналт тавих,

9.6. Иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг судалж, гаргасан тайлан мэдээтэй уялдуулан дүгнэх,

9.7. Шаардлагатай асуудлаар дээд байгууллага, албан тушаалтанд хандаж дэмжлэг хүсэх,

9.8. ХШҮ-ний мөрөөр тодорхой ажил хийгээгүй ахиж өөрчлөлт гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах,

**Арав. Хүрэх үр дүн**

10.1. Төсөв, хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаа ил тод болно.

10.2. Үргүй зардал багас, төсвийн хөрөнгийн өгөөж сайжирна.

10.3. Иргэд, Хурлын төлөөлөгчдийн хяналт сайжирч, оролцоо өргөжинө.

10.4. Хууль журмын хэрэгжилт олон нийтийн хяналтанд орж, зөрчил, дутагдал, эрсдлээс урьдчилан сэргийлэх ажил сайжирна.

**Арваннэг. Хариуцлага**

11.1. Журмын зүйл заалтыг албан байгууллага, хувь хүн мөрдөн ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно.